



БИЗКОН АУДИТ КОМПАНИЙН ХӨВСГӨЛ АЙМАГ
ДАХЬ САЛБАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Нутгийн аваргууд сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/225/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Хөвсгөл аймаг Мөрөн сум 2022 он	Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг Утас: 99016320 Цахим хаяг: erdenechimegg@audit.gov.mn Бизкон аудит ХХК-ийн Ахлах аудитор Ч.Мөнхбаяр Утас: 99996784 Цахим хаяг: mm.bayar0711@gmail.com Аудитор: Л.Пунсал-орлом Утас: 88908680 Цахим хаяг: punsaa73@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Төлбөрийн акт	16
4.3 Албан шаардлага	16
4.4 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУ	Монгол улс



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандөш баг
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас, факс: 70-38 37-93
Э-мэйл: khvsgul@audit.gov.mn
Вэбсайт: www.audit.mn

2022.09.23 № 01/123
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН "НУТГИЙН АВАРГУУД"
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ М.БАТ-ЭРДЭНЭ
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын "Нутгийн аваргууд" сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын "Нутгийн аваргууд" сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР





ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 23 өдөр

№ 07/А2250433/ХӨА-20221
225/АА-СМ.А-НУС

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын "Нутгийн аваргууд" сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Тус байгууллагын төсөвт Мөрөн сумын ИТХ-ын 2021 оны 9 дүгээр сарын 24-ний 02 тоот тогтоолоор 16.5 сая төгрөгийн төсвийн зардал хоорондын зохицуулалт, Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/608 тоот захирамжаар 102.2 сая төгрөгөөр төсвийг нэмэх зохицуулалт, нийт 118.7 сая төгрөгөөр төсвийг нэмэх зохицуулалтыг хийж, санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,024.6 сая төгрөг болгосон байна. 2021 онд цалин, нийгмийн даатгалын шимтгэлээс бусад зардлын 304.4 сая төгрөгөөс 30.4 сая төгрөгийн төсвийг хэмнэлт гаргахаас 8.7 сая төгрөгийн төсөв татан төвлөрүүлсэн бөгөөд 21.7 сая төгрөгийн хэмнэлт гаргаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2022 оны 08 дугаар сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Нутгийн аваргууд" сургуулийн захирал М.Бат-Эрдэнэ, нягтлан бодогч Н.Нямбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР

"БИЗКОН АУДИТ" ХХК-ийн ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
САЛБАРЫН АУДИТОР  Л.ПУНСАЛ-ОРЛОМ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, аймгийн ЗДТГ-ын байрны А корпус 3 давхар 303 тоот, утасны дугаар: 7038 4043

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>72,243,209.73</u>	<u>94,665,837.70</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
33	АВЛАГА	488,279.83	00.00
335	Бусад авлага	488,279.83	00.00
3351	Байгууллагаас авах авлага	488,279.83	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	71,754,929.90	94,665,837.70
351	Түүхий эд материал	1,277,060.00	753,306.67
35130	Эм боох материал	1,277,060.00	753,306.67
354	Хангамжийн материал	70,477,869.90	93,912,531.03
35410	Бичиг хэргийн материал	833,100.00	501,400.00
35420	Аж ахуйн материал	145,200.00	14,123,670.00
35450	Барилгын засварын материал	289,000.00	289,000.00
35470	Бусад хангамжийн материал	69,210,569.90	78,998,461.03
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,248,956,147.43</u>	<u>1,263,999,660.24</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,248,956,147.43	1,263,999,660.24
392	Биет хөрөнгө	1,019,543,647.43	1,186,404,660.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	995,239,176.20	548,246,400.35
39202	Хуримтлагдсан элэгдэл	-90,219,592.73	-48,634,761.45
39203	Авто-тээврийн хэрэгсэл	15,000,000.00	15,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-15,000,000.00	-15,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	117,895,448.93	183,663,393.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	-91,807,888.24	-97,514,013.19
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	83,594,958.40	178,267,430.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-67,569,708.44	-75,322,977.55
39214	Бусад үндсэн хөрөнгө	113,043,911.42	537,377,111.41
39215	Хуримтлагдсан элэгдэл	-64,868,263.74	-66,112,089.93
39217	Ном	24,235,605.63	26,434,166.17
393	Биет бус хөрөнгө	229,412,500.00	77,595,000.00
39301	Програм хангамж	946,000.00	946,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-946,000.00	-946,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	229,412,500.00	77,595,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,321,199,357.16</u>	<u>1,358,665,497.94</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	804,303.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	804,303.00	00.00
413	Өглөг	804,303.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	804,303.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,320,395,054.16</u>	<u>1,358,665,497.94</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,320,395,054.16	1,358,665,497.94
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,020,257,602.87	1,020,257,602.87
51101	Өмч: - төрийн	1,020,257,602.87	1,020,257,602.87
512	Хуримтлагдсан үр дүн	-183,667,849.23	-145,397,405.45
51210	Өмнөх үеийн үр дүн	-183,667,849.23	-183,667,849.23

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Нутгийн аваргууд сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51220	Тайлант үеийн үр дүн	00.00	38,270,443.78
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	483,805,300.52	483,805,300.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,321,199,357.16	1,358,665,497.94

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	977,069,101.10	1,605,232,195.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	975,654,001.10	572,264,771.50
120	Нийтлэг татварын бус орлого	5,939,701.10	572,264,771.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,939,701.10	572,264,771.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	41.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,939,660.10	572,264,771.50
122	Тусламжийн орлого	148,927,400.00	00.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	820,786,900.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	820,786,900.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,415,100.00	209,311,524.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	823,655,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,415,100.00	8,354,624.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	7,369,424.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,415,100.00	985,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	200,956,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	200,956,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,014,632,499.08	1,049,034,987.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,014,632,499.08	1,049,034,987.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	962,961,448.83	1,003,073,987.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	649,291,803.58	635,379,176.83
210101	Үндсэн цалин	547,430,738.28	437,387,153.99
210102	Нэмэгдэл	52,162,533.54	160,251,664.29
210104	Урамшуулал	49,698,531.76	37,740,358.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,596,483.59	84,536,300.00
210201	Тэтгэврийн даатгал	57,088,683.60	59,488,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,956,900.00	6,262,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,621,600.00	5,009,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,175,400.00	1,252,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,753,900.00	12,523,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	132,230,363.00	196,484,400.35
210301	Гэрэл, цахилгаан	3,038,566.00	4,344,409.09
210302	Түлш, халаалт	127,252,013.00	188,282,835.89
210303	Цэвэр, бохир ус	1,939,784.00	3,857,155.37
2104	Хангамж, бараа материалын зардал	15,454,647.75	12,757,910.00

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Нутгийн аваргууд сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	2,366,400.00	4,242,330.00
210402	Тээвэр, шатахуун	3,699,996.75	5,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,121,800.00	929,000.00
210404	Ном, хэвлэл	1,339,100.00	1,084,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,847,951.00	440,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,079,400.00	1,062,080.00
2105	Нормативт зардал	463,565.00	918,657.33
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	463,565.00	918,657.33
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,999,000.00	2,615,800.00
210604	Урсгал засвар	7,999,000.00	2,615,800.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	80,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	80,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	906,900.00	1,342,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	306,900.00	622,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	720,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,018,685.91	68,959,642.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,930,000.00	4,524,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,939,000.00	1,641,790.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	68,149,685.91	62,793,352.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,671,050.25	45,960,999.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,652,700.00	37,253,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,652,700.00	37,253,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	32,559,313.25	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,559,313.25	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,409,037.00	1,947,199.65
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,409,037.00	1,947,199.65
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	50,000.00	6,759,900.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,000.00	6,759,900.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-37,563,397.98	556,197,208.40
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	517,926,764.62
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	108,273.74
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	517,818,490.88
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	00.00	-517,926,764.62
5	НИЙТ ҮР ДҮН	-37,563,397.98	38,270,443.78

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,020,257,602.87	483,805,300.52	-146,104,451.25	1,357,958,452.14

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Нутгийн аваргууд сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,020,257,602.87	483,805,300.52	-146,104,451.25	1,357,958,452.14
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-37,563,397.98	-37,563,397.98
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,020,257,602.87	483,805,300.52	-183,667,849.23	1,320,395,054.16
D01	2021 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,020,257,602.87	483,805,300.52	-183,667,849.23	1,320,395,054.16
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,020,257,602.87	483,805,300.52	-183,667,849.23	1,320,395,054.16
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	38,270,443.78	38,270,443.78
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,020,257,602.87	483,805,300.52	-145,397,405.45	1,358,665,497.94

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	971,403,605.00	1,032,967,424.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	969,988,505.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	274,205.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	274,205.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	274,205.00	00.00
122	Тусламжийн орлого	148,927,400.00	00.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	820,786,900.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	820,786,900.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,415,100.00	1,032,967,424.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	823,655,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,415,100.00	8,354,624.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	7,369,424.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,415,100.00	985,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	200,956,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	200,956,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	956,544,745.00	1,002,867,424.00

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Нутгийн аваргууд сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

21	УРСГАЛ ЗАРДАЛ	956,544,745.00	1,002,867,424.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	904,873,694.75	956,906,424.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	648,487,500.00	635,695,200.00
210101	Үндсэн цалин	546,626,435.00	437,703,177.16
210102	Нэмэгдэл	52,162,533.54	160,251,664.29
210104	Урамшуулал	49,698,531.46	37,740,358.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,084,764.00	84,536,300.00
210201	Тэтгэврийн даатгал	57,576,964.00	59,488,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,956,900.00	6,262,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,621,600.00	5,009,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,175,400.00	1,252,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,753,900.00	12,523,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	132,230,363.00	196,484,400.35
210301	Гэрэл, цахилгаан	3,038,566.00	4,344,409.09
210302	Түлш, халаалт	127,252,013.00	188,282,835.89
210303	Цэвэр, бохир ус	1,939,784.00	3,857,155.37
2104	Хангамж, бараа материалын зардал	13,471,901.00	20,273,124.00
210401	Бичиг хэрэг	406,900.00	1,111,520.00
210402	Тээвэр, шатахуун	3,500,000.00	5,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,121,800.00	929,000.00
210404	Ном, хэвлэл	1,339,100.00	1,224,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,085,301.00	574,904.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,018,800.00	11,433,400.00
2105	Нормативт зардал	2,434,530.00	769,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,982,230.00	260,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	452,300.00	509,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,478,140.00	2,525,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	190,140.00	00.00
210604	Урсгал засвар	8,288,000.00	2,525,300.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	80,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	80,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	906,900.00	5,732,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	306,900.00	5,012,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	720,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,779,596.75	10,809,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,930,000.00	6,616,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,849,596.75	4,193,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,671,050.25	45,960,999.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,652,700.00	37,253,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,652,700.00	37,253,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	32,559,313.25	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,559,313.25	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,409,037.00	1,947,199.65

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Нутгийн аваргууд сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,409,037.00	1,947,199.65
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	50,000.00	6,759,900.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,000.00	6,759,900.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	14,858,860.00	30,100,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	14,858,860.00	30,100,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,858,860.00	30,100,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	14,858,860.00	30,100,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,858,860.00	30,100,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-14,858,860.00	-30,100,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,024,612,800.00	1,015,905,700.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,024,612,800.00	1,015,905,700.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	981,780,500.00	978,651,800.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	635,695,200.00	635,695,200.00
210101	Үндсэн цалин	460,474,900.00	437,703,177.16
210102	Нэмэгдэл	135,520,300.00	160,251,664.29
210104	Урамшуулал	39,700,000.00	37,740,358.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,454,300.00	84,536,300.00
210201	Тэтгэврийн даатгал	60,134,500.00	59,488,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,330,000.00	6,262,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,063,900.00	5,009,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,266,000.00	1,252,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,659,900.00	12,523,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	198,431,600.00	196,484,400.35
210301	Гэрэл, цахилгаан	6,000,000.00	4,344,409.09
210302	Түлш, халаалт	184,931,600.00	188,282,835.89

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Нутгийн аваргууд сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	7,500,000.00	3,857,155.37
2104	Хангамж, бараа материалын зардал	18,968,500.00	18,968,500.00
210401	Бичиг хэрэг	892,000.00	892,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,000,000.00	5,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	929,000.00	929,000.00
210404	Ном, хэвлэл	274,100.00	274,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	440,000.00	440,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,433,400.00	11,433,400.00
2105	Нормативт зардал	769,900.00	769,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	260,000.00	260,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	509,900.00	509,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,625,300.00	32,625,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,800,000.00	19,800,000.00
210602	Тавилга	10,300,000.00	10,300,000.00
210604	Урсгал засвар	2,525,300.00	2,525,300.00
2107	Томилолт, зочны зардал	80,000.00	80,000.00
210702	Дотоод албан томилолт	80,000.00	80,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,462,600.00	1,432,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	712,600.00	712,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	750,000.00	720,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8293100.00	8059600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,100,000.00	3,866,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,193,100.00	4,193,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42832300.00	37253900.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,832,300.00	37,253,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,832,300.00	37,253,900.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,024,612,800.00	1,015,905,700.35
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	823,655,900.00	816,896,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	823,655,900.00	816,896,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	200,956,900.00	199,009,700.35
132001	Орон нутгийн төсвөөс	200,956,900.00	199,009,700.35
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	00.00	00.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	59.00	59.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	40.00	40.00
620003	Үйлчлэх ажилтан	18.00	18.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,354,624.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,354,624.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,354,624.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,304,624.00
210401	Бичиг хэрэг	219,520.00
210404	Ном, хэвлэл	950,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	134,904.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,300,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,750,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,750,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8354624.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,354,624.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,369,424.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	985,200.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Нутгийн аваргууд сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд авлага, үндсэн хөрөнгө, зардал, цалингийн суутгалтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Бизкон Аудит ХХК-ийн гэрээт аудитор Л.Пунсал-Орлом, туслах аудитор Б.Түмэндэмбэрэл нар гүйцэтгэж, хяналтыг Бизкон Аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Мөнхбаяр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Нутгийн аваргууд сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Нутгийн аваргууд сургууль нь төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаа явуулдаг Мөрөн сумын Засаг даргын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хөвсгөл аймгийн засаг даргын 2019 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн А/375 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тус байгууллага нь мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасны дагуу Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Нутгийн аваргууд сургууль нь 2021 оны А/25 тоот тушаалаар дотоод хяналт шалгалтын зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна. Тайлант онд 6 ажил гүйцэтгэхээр төлөвлөгөө батлуулан ажиллаж дотоод хяналтын ажлын тайлан бичсэн боловч хангалтгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Нутгийн аваргууд сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,014.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 20.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 16.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Нутгийн аваргууд сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 53.1 сая төгрөгөөр буюу 4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00	00	00
Авлага	0.5	00	-0.5
Урьдчилгаа	00	00	00
Бараа материал	71.8	94.7	22.9
Үндсэн хөрөнгө	1,248.9	1,279.6	30.7
Нийт хөрөнгө	1,321.2	1,374.3	53.1
Өр төлбөр	0.8	0	-0.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,320.4	1,374.3	53.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,321.2	1,374.3	53.1

Тайлант онд БШУЯ-аас үнэ төлбөргүйгээр 75 нэр төрлийн 145.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, БСГ-аас 49 нэр төрлийн 2.1 сая төгрөгийн ном, Мөрөн сумын ЗДТГ-аас 26 нэр төрлийн 398,2 сая төгрөгийн бусад хөрөнгө, АСЕМ-ийн буцалтгүй тусламжаар 7 нэр төрлийн 12.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, элэгдлээрээ өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой 7 нэр төрлийн 1.5 сая төгрөгийн өртөгтэй бусад хөрөнгийг дахин үнэлж орлого авсан, төсвийн хөрөнгөөр 9 нэр төрлийн 36.0 сая төгрөгийн хөрөнгө, нийт 595.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Мөн Хөвсгөл аймгийн ЗДТГ-т 4 нэр төрлийн 592.4 сая төгрөгийн барилга байгууламжийг шилжүүлсэн, дахин үнэлэхээр 7 нэр төрлийн 9.8 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хассан, 6 нэр төрлийн 3.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 5 нэр төрлийн 1.6 сая төгрөгийн бусад хөрөнгө, нийт 5.4 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагын тушаал, шийдвэрийг үндэслэн акталж устгасан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 860.7 сая төгрөгөөр төлөвлөж санал хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн саналаас 15.9 сая төгрөгөөр бууруулж 844.8 сая төгрөгөөр 2021 оны төсвийг баталсан байна. Тус байгууллагын төсөвт Хөвсгөл аймгийн засаг даргын 2021 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн А/281 тоот захирамжаар 7.9 сая төгрөгөөр төсвийг хасах зохицуулалт, Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 01 тоот тогтоолоор 85.5 сая төгрөгийн төсвийг нэмэх зохицуулалт, Мөрөн сумын ИТХ-ын 2021 оны 9 дүгээр сарын 24-ний 02 тоот тогтоолоор 16.5 сая төгрөгийн төсвийн зардал хоорондын зохицуулалт, Хөвсгөл аймгийн засаг даргын 2021 оны 12

дугаар сарын 07-ны өдрийн А/608 тоот захирамжаар 102.2 сая төгрөгөөр төсвийг нэмэх зохицуулалт, нийт 187.7 сая төгрөгөөр төсвийг нэмэх зохицуулалтыг хийж, санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,024.6 сая төгрөг болгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагааны хүрээнд 1 хөтөлбөрийн 4 зориулалт арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,024.6 сая төгрөгийн төсөв баталсан ба 823.7 сая төгрөгийг улсын төсвийн хөрөнгөөр, 200.9 сая төгрөгийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны хүрээнд улсын төсвөөс 823.7 сая төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 200.9 сая төгрөг, нийт 1,024.6 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж 1,015.9 сая төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулж, 8.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,015.9 сая төгрөг буюу 99.1 хувьтай байгаа нь үдийн цай арга хэмжээний гүйцэтгэл гол нөлөө үзүүлсэн байна. Хөтөлбөр, арга хэмжээний зардлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. Төсвийн гүйцэтгэлийн тайлан /үндсэн/ /сая төгрөг/

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
71802	Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөр	1,024.6	1,015.9	8.7	99.1
80109	ТШЗ-ийн байгууллагуудын тогтмол зардал	200.9	199.0	1.9	99.0
81801	Үдийн цай	42.8	37.2	5.6	87.0
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	579.2	578.9	0.3	100
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	201.7	200.8	0.9	99.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагааны хүрээнд 2 хөтөлбөрийн 2 зориулалт арга хэмжээг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгасан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 7.4 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1.0 сая төгрөг, нийт 8.4 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж дээд шатны эрх бүхий байгууллагын шийдвэрээр бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бичиг хэрэг, ном хэвлэл, бараа үйлчилгээний бусад зардал, хог хаягдал, хортон мэрэгчдийг устгах зардлуудад 8.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу цахим засаглал үндэсний хөтөлбөрийн хүрээнд биет болон биет бус хөрөнгийг бүртгэлд тусгасан эсэх, зориулалтын дагуу бүрэн ашиглаж байгаа эсэх асуудлуудыг тусгайлан авч үзэж, үр дүнг тайлагнахаар төлөвлөгөөнд тусгасны дагуу шалгахад асуудалтай зүйл илэрсэнгүй. Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна. Энэ нь 14 дүгээр хороонд хичээлийн шинэ байр ашиглалтанд орсонтой холбоотой бүх урсгал зардал өссөн байна. Тус байгууллагын тайлант оны гүйцэтгэлийг өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад нормативт зардлыг 68.4 хувь буюу 1.7 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 70.2 хувь буюу 6.0 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 39.2 хувь буюу 6.9 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн ч хэмнэлтийн тооцоогоор 18.0 сая төгрөгийн хэтрэлттэй байна. Энэ нь 14 дүгээр хороонд хичээлийн шинэ байр ашиглалтанд орсонтой холбоотой байр ашиглалттай холбоотой тогтмол зардал өссөн байна.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан. Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

МУ-ын ерөнхий аудиторын 2021 оны 10 дугаар сарын 08-н ы өдрийн А/92 тоот тушаалаар баталсан аргачлалын дагуу шалгахад алдаа зөрчил илэрсэнгүй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Нутгийн аваргууд сургуулийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх дүрмийн сангийн хэмжээ 1,020.3 сая төгрөг, санхүүгийн тайлан дахь төрийн болон орон нутгийн эзэмшлийн өмчийн дүн 1,020.3 сая төгрөгтэй таарч байна. Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаж байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн 2 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд шинээр 14 дүгээр хороонд сургуулийн барилга ашиглалтанд орсон боловч бүртгэлд барилга байгууламж, газар эзэмших эрх зэрэг хөрөнгүүдийг бүртгэлд тусгаагүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 126.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 58.2 сая төгрөгийн алдааг залруулж, 21.7 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 46.7 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Нутгийн аваргууд спортын ахлах сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын дараах алдааг санхүүгийн тайланд залруулав. Үүнд:

1. Тайлант оны 4-р улирлын үндсэн хөрөнгийн элэгдэл бодуулаагүй, элэгдлийн зардал 15.6 сая төгрөгийг бүртгэлд дутуу тусгасныг залруулав.
2. Тайлант оны үндсэн цалингийн зардлаас нэмэгдэл цалингийн зардалд 9.7 сая төгрөгийг, цалингийн зардлаас НДШ-ийн зардалд 10.7 сая төгрөгийг, нэмэгдэл цалингийн зардлаас үндсэн цалингийн зардалд 11.2 сая төгрөгийг, НДШ-ийн зардлаас цалингийн зардалд 10.7 сая төгрөгийг, нийт 42.3 сая төгрөгийг илүү бүртгэснийг залруулав.
3. Тайлант онд цалингаас суутгаагүй хамтын санд өгөх 0.3 сая төгрөгийг ажиллагчидтай холбогдсон өглөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэснийг залруулав.

4.2 Төлбөрийн акт

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Нутгийн аваргууд сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж цалин, нийгмийн даатгалын шимтгэлээс бусад зардлаас 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй тул Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Нутгийн аваргууд сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 21.7 сая төгрөгийн албан шаардлага өгсөн болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагатай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант оны Нийгмийн даатгалын байгууллагаас авах авлагын эхний үлдэгдэл 0.5 сая төгрөгийг ажиллагсадтай холбоотой авлагаар бүртгэсэн байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

НББ-ийн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д заасны дагуу авлагыг хянаж, үнэн зөв бүртгэх

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант онд ОНӨГ-аас зохих шийдвэргүйгээр нийт 7 нэр төрлийн 35.8 сая төгрөгийн хөрөнгийг урсгал зардлын санхүүжилтаас бэлтгэсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 3-д "Төрийн өмчит хуулийн этгээд үл хөдлөх хөрөнгийг захиалгын үндсэн дээр зөвхөн төрийн өмчийн бодлого,

зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр олж авна" гэж заасныг зөрчиж байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн дагуу ОНӨГ-т саналаа хүргүүлэн тушаал, шийдвэр гаргуулж үндсэн хөрөнгө бэлтгэж хэвших.

3. **Зардалтай холбоотой асуудал**

3.1. Илрүүлэлт:

Тайлант онд БҮТЭЗ-ийн зардлаас 10.4 сая төгрөгийн эд хогшил худалдан авсан байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчиж байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг мөрдөж батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилалын дагуу зарцуулж хэвших.

4. **Цалингийн суутгалтай холбоотой асуудал**

4.1. Илрүүлэлт:

Тайлант онд ажиллагсдын гарт олгох цалингаас хамтын сангийн 10.3 сая төгрөг, ҮЭ-ийн 3.8 сая төгрөг, утасны төлбөр 4.5 сая төгрөг, нийт 18.6 сая төгрөгийг суутгасан байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1-д "Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно", 119.1.1-д "ажилтны нэг сарын дундаж цалин хөлснөөс хэтрэхгүй хэмжээний хохирлыг ажилтнаар нөхөн төлүүлэх тухай ажил олгогчийн шийдвэр гарсан", 119.1.2-т "шүүхийн, эсхүл хөдөлмөрийн эрхийн маргаан шийдвэрлэх байгууллагын шийдвэр хүчин төгөлдөр болсон", 119.1.3-д "ажилтанд энэ хуулийн 123.2.3-т заасан хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулсан", 119.1.4-д "хууль тогтоомжид заасан бусад тохиолдол" гэж заасныг зөрчиж байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Ажиллагсдын цалингаас Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлд зааснаас бусад суутгалыг суутгахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

/Э.БАТ-ЭРДЭНЭ/

Огноо:

АХЛАХ АУДИТОР

/Г.ЭРДЭНЭЧИМЭГ/

Огноо:

БИЗКОН АУДИТ ХХК-ЫН АХЛАХ АУДИТОР

/Ч.МӨНХБАЯР/

Огноо:

БОЛОВСРУУЛСАН:

БИЗКОН АУДИТ ХХК-ЫН ГЭРЭЭТ АУДИТОР

/Л.ПУНСАЛ-ОРЛОМ/